



(https://www.facebook.com/AsigtMaltmalynGazar?fref=ts)



(https://twitter.com/)



(https://plus.google.com/)



(https://www.linkedin.com/)



(http://mram.gov.mn/?p=1940&lang=MN)



(http://mram.gov.mn/?p=1940&lang=en)

Саналын урилга (http://mram.gov.mn/?p=1940)

Оруулсан:mram (http://mram.gov.mn/?author=1) © 2016/05/16

Ашигт малтмалын газар нь Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2014 оны 216 дугаар тогтоол, Уул уурхайн сайдын тушаалыг тус тус үндэслэн дор дурдсан талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зарлаж, оролцох аж ахуйн нэгжүүдийг санал ирүүлэхийг урьж байна.

Солбицолыг энд дарж (http://mram.gov.mn/wp-content/uploads/2016/05/2016.05.16.xlsx) татаж авна уу.

1. Сонгон шалгаруулалт нь дор дурдсан нутгийг хамарсан нэр бүхий талбайд зарлагдана. Үүнд:

№	Талбайн нэр	Талбайн хэмжээ /га/	Аймаг	сум
1.	Нарангийн гол-2	370.03 га	Сэлэнгэ	Баянгол
2.	Нарангийн гол-1	664.81 га	Сэлэнгэ	Баянгол
3.	Зүүн хоолой	3284.09 га	Дорнод	Баянтүмэн

2. Сонгон шалгаруулалт зарласан талбайн солбицол, болон бусад мэдээллийг Ашигт малтмалын газрын цахим хуудаснаас (mram.gov.mn (http://www.mram.gov.mn)) авна уу. Мөн Ашигт малтмалын газраас авч болно.
3. Үнэлгээний баримт бичгийн иж бүрдэл, босго үнийн талаарх мэдээллийг эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр үйлчилгээний хураамж болох 250.000 төгрөгөөр худалдан авна.
4. Сонгон шалгаруулалтад оролцох саналыг 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн өглөөний 09 цаг хүртэлх хугацаанд Ашигт малтмалын газрын 309 тоот өрөөнд Сонгон шалгаруулалт явуулах комиссын нарийн бичгийн дарга хүлээн авна.
5. Сонгон шалгаруулалтад оролцох саналыг сонгон шалгаруулалтанд оролцогч аж ахуйн нэгжийн захирал эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг байлцуулан 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 09.00 цаг 30 минутад Ашигт малтмалын газрын хурлын танхимд нээнэ. Аж ахуйн нэгжийн захирал эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь тогтоосон хугацаанд ирээгүй нь сонгон шалгаруулалтад оролцох саналыг нээхгүй байх үндэслэл болохгүй.
6. Ирүүлсэн саналыг Монгол улсын Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 216 дугаар тогтоолоор баталсан сонгон шалгаруулалтын тусгай журам, Ашигт малтмалын газрын даргын

тушаалаар баталсан үнэлгээний баримт бичигт заасны дагуу сонгон шалгаруулах комисс үнэлнэ.

7. Сонгон шалгаруулалтад оролцох санал ирүүлэх хаяг: Засгийн газрын 12 дугаар байр, Барилгачдын талбай-3, Ашигт малтмалын газар 309 тоот өрөө, Сонгон шалгаруулалт явуулах комиссын нарийн бичгийн дарга, утас 263704
8. Сонгон шалгаруулалтад оролцогч нь үнэлгээний баримт бичигт заасны дагуу саналаа бэлтгэх бөгөөд саналд дараах бичиг баримтыг хавсарган ирүүлнэ. Үүнд:
 - Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт / сонгон шалгаруулалтад санал болгож буй үнийн дүнг бичсэн /
 - Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (*нотариатаар баталгаажуулсан*)
 - Талбайн нэр, байршил, аймаг, сумын нэр, талбайн булангийн цэгүүдийн солбицол, талбайн байршил, хилийг харуулсан зураг (2%) /АМТХ-ийн 17.2.1, 17.4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байх/
 - Үйлчилгээний хураамж 250 000 төгрөгийг Төрийн сан – 900018003 тоот дансанд төлсөн баримт (*төлбөрийн баримтын эх хувь*)
 - Татварын өргүй тухай тодорхойлолт (*харьяа татварын албанаас*)
 - Хууль хяналтын байгууллага болон шүүхийн маргаангүй талаарх лавлагаа
 - Сонгон шалгаруулалтын босго үнийн 30 ба түүнээс дээш хувийг Төрийн сан 900018408 тоот дансанд төвлөрүүлсэн баримт (*төлбөрийн баримтын эх хувь*)
 - Тухайн талбайд санал болгосон үнийг төлөх чадвартайг нотлох банкны баталгаа / Монгол банкинд бүртгэлтэй харилцагч банкнаасаа тухайн аж ахуйн нэгжийн нэр дээр авсан байх / хавсаргах
 - Геологи хайгуулын ажлын төслийн баримт бичиг / Тухай талбайд эхний нэг жилд хийж гүйцэтгэх геологи хайгуулын ажлын арга аргачлал, техник тоног төхөөрөмж, ажиллах хүчин, байгаль орчны нөхөн сэргээлтийн талаар тусгасан 10 хуудсаас доошгүй Геологи хайгуулын ажлын төслийн баримт бичиг ирүүлэх/
 - Аж ахуйн нэгжийн танилцуулга

Ашигт малтмалын газар

Like { 0

Tweet

Share { 0

Мэдээг үнэлэх

[Нийт: 0 Дундаж: 0]



(<http://mram.gov.mn/?p=1940&print=1>) Мэдээг хэвлэх (<http://mram.gov.mn/?p=1940&print=1>)